

Ханбогд сумын Гурван талт зөвлөлийн ХАМТАРСАН МЭДЭЭЛЭЛ

**Өмнөговь аймаг
Ханбогд сум**

2017 оны 05-р сарын 9

Ханбогд сумын Гурван талт зөвлөлийн (ГТЗ)¹ хурал 2017 оны 05 дугаар сарын 02 болон 08-09-ны өдрүүдэд Иргэдийн хөгжлийн төвд боллоо. Хуралд ГТЗ-ийн гишүүд, Эрх зүйн Нийцэл Хяналт, Зөвлөгөө, Омбудсмений газрын (ЭЗНХЗОГ)² чиглүүлэгч нар болон Малчдын төлөөлөл зөвлөхөөр ОТ Хяналт ТББ-ийн төлөөлөл оролцлоо.

Талууд энэ хурлаар Ундайн голын голидрол өөрчилсөнтэй холбоотой гомдол болон ОТ-н төслийн улмаас нутаг орны бэлчээрийн газар, усны нөөцийг ашигласнаас үүдэн малчдын нүүдлийн амьжиргааг доройтуулж, улмаар тэдний уламжлалт соёл, амьжиргаанд эрсдэл учруулж байгаа явдал болон нөхөн олговор болон нүүлгэн шилжүүлэлт зохих ёсоор хийгдээгүй, ялангуяа усны нөөц ховор бүс нутагт тогтвортой ус ашиглалтын асуудлыг тойрсон төслийн ажиллагаа зүй зохистой эсэхэд эргэлзсэн зэрэг гомдлын асуудлыг шийдвэрлэх тохиролцоогоо баталгаажуулж, Малчдын гомдлыг барагдуулах хоёр гэрээнд гарын үсэг зурлаа. Ингэж гэрээ байгуулснаар хоёр гомдлыг барагдуулах үйл явц яриа хэлэлцээний шатнаас хэрэгжилтийг хангах, хянах үе шатанд шилжиж байна.

Гэрээнд заасны дагуу Малчдын гомдлыг барагдуулах Үйл ажиллагааны дэлгэрэнгүй төлөвлөгөөг хэрэгжүүлэх үүргийг хариуцсан талууд хүлээнэ. Уг төлөвлөгөөнд Талуудын тохирсон ажил нэг бүрийг хэрэгжүүлэх хугацаа, хариуцах тал, үр дүнгийн гүйцэтгэлийн шалгуурыг тусгасан болно. ЭЗНХЗОГ нэг жилийн хугацаанд гэрээний хэрэгжилтэнд хяналт хийж, Гэрээ амжилттай хэрэгжиж байгаа эсэх талаар дүгнэлт гаргана.

Ийнхүү Малчдын гомдлыг яриа хэлэлцээний замаар шийдвэрлэхийн тулд Талууд багагүй хугацааг зарцуулж, тууштай хамтран ажилласнаар шийдэлд хүрч чадлаа. Энэ хугацаанд Талуудын харилцан итгэлцэл нэмэгдэж, хамтын ажиллагааны суурь бэхжсэн гэдэгт Талууд итгэлтэй байна. Гомдол шийдвэрлэх яриа хэлэлцээний дүн нь зөвхөн гомдол гаргагчдын асуудлыг шийдэхээс гадна Ханбогд сумын нийт малчдад үр өгөөжтэй өргөн хүрээний ажил боллоо гэж Талууд санал нэгтэй дүгнэж байна. Зөвлөлийн гишүүд энэхүү яриа хэлэлцээг амжилттай хөтөлж, чиглүүлж ажилласан ЭЗНХЗОГ-ийн чиглүүлэгч нарын мэргэжлийн үр чадвар, хичээл зүтгэлийг өндрөөр үнэлж гүн талархал илэрхийллээ.

Мөн хурлаар Нөхөн олговрын нэхэмжлэлийн хорооны журмыг эцэслэн тохирлоо. Энэхүү журамд заасны дагуу шалгуурт нийцсэн малчин өрхийн нэхэмжлэлийг 2004, 2011 оны нөхөх олговрын хөтөлбөрт хамруулахаар хөөн хэлэлцэж шийдвэрлэх үйл ажиллагааг зохицуулна. Гурван талт зөвлөл энэ журмыг хэрэгжүүлж, Нөхөн олговрын нэхэмжлэлийн хорооны үүргийг гүйцэтгэж ажиллах юм.

Талуудын байгуулсан Малчдын гомдол барагдуулах гэрээ болон Нөхөн олговрын нэхэмжлэлийн хорооны журмыг ОТ компанийн хэвлэн гаргадаг Орон нутгийн сонины тусгай дугаарт нийтлэн Ханбогд сумын малчдад хүргэх болно. Мөн Ханбогд сумын багуудын иргэдийн нийтийн хурал дээр ГТЗ-ийн төлөөллүүд оролцож мэдээлэл хүргэнэ.

Ханбогд сумын Гурван талт зөвлөл

¹ Ханбогд сумын Сумын удирдлага, Малчдын төлөөлөгчид болон Оюу толгой компанийн хамтарсан Гурван талт зөвлөл (ГТЗ) нь талуудын маргааныг шийдвэрлэх зорилгоор Харилцан ойлголцлын санамж бичигт зурсны дагуу 2015 оны 6 сарын 8-нд албан ёсоор байгуулагдсан болно. ГТЗ-ийн үйл ажиллагааг Эрх зүйн Нийцэл Хяналт, Зөвлөгөө, Омбудсмений газраас (ЭЗНХЗОГ) чиглүүлж байна.□

² Эрх зүйн Нийцэл Хяналт, Зөвлөгөө, Омбудсмений Газар (ЭЗНХЗОГ) бол Дэлхийн Банкны Группын Олон улсын санхүүгийн корпорацийн (ОУСК) болон Олон Талын Хөрөнгө Оруулалтын Баталгааны Байгууллагатай (ОТХОББ) холбоотой асуудлаар хөндлөнгийн хараат бус хариуцлагын механизмын үйлчилгээ үзүүлдэг хараат бус, бие даасан байгууллага болно.□□